

ЗҮҮН ӨМНӨД АЗИЙН ИНТЕГРАЦИЙН ШИНЭ ХАНДЛАГА БА МОНГОЛ УЛС

*С.Дашцэвэл**

1. АСЕАН-ы интеграцийн шинэ хандлага

1990-ээд оноос АСЕАН-ы орнуудын удирдлага үндэсний болон бүс нутгийн чадавхийг улам илүү нээж, эрчимтэй хөгжихийн тулд эдийн засгийн нилээд дээд түвшний хамтын ажиллагаа буюу интеграц руу анхаарлаа чиглүүлэв. Иймд 1992 онд АСЕАН-ы чөлөөт худалдааны бүс (АФТА)-ийг албан ёсоор зарласан билээ.

2008 он гэхэд АСЕАН-ы гишүүн 6 орон АФТА-ийн хөтөлбөрийг үндсэндээ хэрэгжүүлээд байна. Харин АСЕАН-д шинээр нэгдсэн 4 орон дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зохистой аргыг сүвэгчилж, үндэсний бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг аль болох түргэн нэмэгдүүлж байж 2015-2018 онд хэрэгжүүлж дуусгах юм.¹

Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнуудад хөрөнгө оруулалт өсөхийн хамт үйлдвэрлэл, үйлчилгээний хөгжлийн шинэ үе эхлэв. Энэ нь АСЕАН-ы орнуудад аж үйлдвэрийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах боломж олгов.

Урьд нь аж үйлдвэрийн салбарт хамтын ажиллагааны төлөвлөгөө, хөтөлбөр гэх мэтийг хэрэгжүүлж байсан бөгөөд түүнээс зарчмын ялгаатай АІСО (Asean Industrial Cooperation) хэмээх аж үйлдвэрийн хамтын ажиллагааны механизм 1996 онд бий боллоо. АІСО нь АСЕАН-ы орнуудын аж үйлдвэр, түүний дотор жижиг дунд үйлдвэрийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжээд зогсохгүй АСЕАН-ы дотоодын болон гадаад түншүүдийн хөрөнгө оруулалтыг АСЕАН-ы үйлдвэрлэлийн салбарт нэгтгэх, гишүүн орнуудын хөрөнгө чөлөөтэй шилжих илүү таатай нөхцөл бүрдүүлэх зорилготой механизм юм. АІСО-г бас АСЕАН-ы орнуудын аж үйлдвэрийн хамтын ажиллагааны байгууллага буюу бүтэц /arrangement/ ч гэж ойлгож болно. АІСО нь үйлдвэрийн хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах идэвхжүүлэхийн тулд тусгай нөхцөл хангасан үйлдвэр, корпорациудыг өөртөө нэгтгэн тэдний үйл ажиллагааг зангидан залуурдах үүрэгтэй юм. АІСО-ын үйл ажиллагаа нь дараах үндсэн асуудалд чиглэгдэж буй. Үүнд:

1. Боловсруулах үйлдвэрлэлийн салбарын үүргийг өндөр болгох;
2. АСЕАН-ы доторх аж үйлдвэрийн бүтээгдэхүүний худалдааг дэмжих;
3. Зарим төрлийн үйлдвэрлэлийг онцлон анхаарч нэгдсэн бодлогын дагуу хэрэгжүүлэх;

* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан доктор (Ph.D), дэд профессор

4. Шинэ тутам элссэн гишүүн орнуудад техник технологийн дэмжлэг үзүүлэх г.м.²

Мөн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогоор зохицуулж, гишүүн орнуудын хөрөнгө өөр хоорондоо чөлөөтэй шилжих, гадаадын хөрөнгө АСЕАН-ы бүсэд урсан орох таатай нөхцлийг бүрдүүлэхийн тулд АСЕАН-ы хөрөнгө оруулалтын бүс AIA /Asian Investment Area/-ын тухай гэрээг 1998 онд байгуулав. Энэ гэрээг 2 жил тутам тодотгож амжилттай хэрэгжүүлж байна.

ХАА-н түүхий эдийг боловсруулах орчин үеийн техник технологи бүхий үйлдвэрлэлд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих замаар бүс нутгаа аюулгүй цэвэр хүнсээр хангаад зогсохгүй дэлхийн зах зээлд өрсөлдөж энэ чиглэлээр Азид төдийгүй дэлхийд тэргүүлэх бүс нутаг болохоор шамдаж байна.

1995 онд АСЕАН-ы орнууд үйлчилгээний салбарын хамтын ажиллагааны гэрээнд анх гарын үсэг зурсан бөгөөд энэ үеэс эхлэн үйлчилгээний салбарт олон төрлийн хөтөлбөр, төсөл хэрэгжүүлж эхлээд байна. Энэ нь бүхэлдээ үйлчилгээний бизнесийг үр ашигтай хөгжүүлэхэд чиглэгджээ.

Дээрх төрөл бүрийн үйлчилгээний салбараар мэргэжил эзэмшигчдийн мэргэжлийн түвшин туршлага болон ажиллах эрхийг харилцан хүлээн зөвшөөрч эхлэв. Энэ нь АСЕАН-ы орнуудын хөдөлмөрийн урсгалыг чөлөөлөхөд түлхэц болж байна.

Товчоор хэлбэл, АСЕАН-ы орнууд АФТА, АІСО, АІА зэрэг механизмууд бий болгож худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалтын салбарт хамтын ажиллагааг хүчтэй болгож байгаа нь АСЕАН-ы эдийн засгийн интеграцийг тууштай хөгжүүлэх чухал алхам болж байна.

1977 оноос АСЕАН-ы гишүүн орнууд англи хэлийг АСЕАН-ы албан ёсны хэл, ам.долларыг тооцооны гол хэрэгсэл болгохоор сонгосон билээ. Төлбөрийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тодорхой хэмжээний дундын санг бүрдүүлсэн байна. Гишүүн орон бүр 40 сая ам.доллаароор санг бүрдүүлж зээлийн дээд хэмжээг 200 саяар тогтоосон.³ 1990-ээд оны санхүүгийн хямралаас сургамж авч бүс нутгийн мөнгөний нэгдсэн систем бий болгох асуудлыг хөндөх болов.

АСЕАН-ы гишүүн орнууд банк, санхүү, бүртгэл тооцоо, даатгал, татварын талаар үйл ажиллагаагаа уялдуулж байгаа нь бүсийн худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэж байна. Төв банкуудын хооронд хамтын ажиллагаа амжилттай хөгжиж гүйлгээг хөнгөн шуурхай болгосноос гадна мөнгөний нэгдсэн системд орох асуудлыг судалж эхлээд байна.

2003 онд хуралдсан АСЕАН-ы дээд хэмжээний уулзалтаас АСЕАН-ы орнуудын интеграцийг улам гүнзгийрүүлэхэд чиглэсэн нэгэн

чухал шийдвэр гаргав. Энэ нь АСЕАН-ы холбоог хамтын нийгэмлэгийн төвшинд яаралтай хүргэх тухай асуудал юм.

Ингэхдээ юуны өмнө эдийн засаг, улс төр, аюулгүйн болон нийгэм соёлын гэсэн 3 үндсэн салбарыг хамтын нийгэмлэгийн түвшинд хүргэхээр шийдвэрлэв.⁴

Чухамхүү энэ чиглэлээр хамтын нийгэмлэгийн түвшинд хүрч байж АСЕАН-ы хамтын нийгэмлэг бүрэн утгаараа хэрэгжих аж. Энэ зорилт нь онолын хувьд бол АСЕАН-ы чөлөөт бүс (АФТА) бүрэн хэрэгжсэний дараа Гаалийн холбоо ба нэгдсэн зах зээлийн үе шатыг туулж байж сая хүрдэг жамтай. Энэ нь юуны өмнө зардлыг үлэмж хэмнэж АСЕАН-ы бараа таваар олон улсын зах зээлд өрсөлдөх боломж бүрдүүлэхийн тулд бүс нутгийн хүрээнд ажиллах хүч, бараа үйлчилгээ, чөлөөтэй шилжиж байх тийм түвшинд хүрнэ гэсэн үг.

АСЕАН-ы орнууд энэ зорилтоо 2020 он гэхэд хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Европын холбоо хамтын нийгэмлэгийн зорилтыг хэрэгжүүлэхэд 30 жил зарцуулсан бол АСЕАН-ы холбоо 17 жилийг (2005-2020) зарцуулахаар төлөвлөж байна. Ийм богино хугацаанд хэрхэн яаж энэ зорилгод дөхөж очих талаар судлаачид санал бодлоо уралдуулсаар байна. Түүний дотроос хамгийн бодитой хэмээн үзэж буй нэгэн загварыг энд дурдъя. Энэ нь Сингапур дахь Зүүн Өмнөд Азийн хүрээлэн (ISEAN)-гийн эрдэмтдийн боловсруулсан загвар бөгөөд Зүүн Өмнөд Азийн орнуудын ихэнх нь хүлээн зөвшөөрч байгаа юм. Энэ загварт дурдсанаар бол АСЕАН-ы Эдийн засгийн хамтын нийгэмлэг (ASEAN Economic community) нь интеграцийн 3 үе шатыг дамжин хэрэгжих аж.

1-р үед, АСЕАН-6 (буюу анхны гишүүн 6 орон)-ийн хооронд бүх төрлийн худалдааны гааль, татварыг бүрмөсөн чөлөөлөх (2008 он гэхэд энэ нь бүрэн хэрэгжинэ),

2-р үед тэдний хооронд бүх төрлийн үйлчилгээ хөрөнгө оруулалтыг гааль, татвараас чөлөөлөх, түүний дараа АСЕАН-ы бусад 4 гишүүн (Вьетнам, Лаос, Камбож, Мьянмар) өөрсдийн боломж, нөхцөл бүрдмэгц мөн бүх төрлийн гааль, татвараас чөлөөлөгдөх

3-р үед бүх гишүүн орнуудын хооронд хөдөлмөр, хөрөнгө оруулалт чөлөөтэй шилжих нөхцлийг бүрдүүлэх.⁵

Энэ 3 үе шатны үйл явц нэгдэж байж сая нэгдсэн зах зээлийг (common market) бий болгох бөгөөд нэгдсэн зах зээл бий болсон нөхцөлд сая АСЕАН-ы хамтын нийгэмлэг (АЕС) биеллээ олох нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Иймд 2020 оны зорилтыг хэрэгжүүлэхийн төлөө АСЕАН-ы орнууд мэрийн хичээж байна.

Үүнд хамгийн гол нь улс орон бүрийн үндэсний эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх явдал гэж үзэж байна. Энэ зорилтыг

хэрэгжүүлэх хугацааг 2015 он болгон наашлуулах саналыг АСЕАН-ы зарим орон дэвшүүлж байна. Учир нь АСЕАН + Хятадын чөлөөт худалдааны бүсийг хэрэгжүүлэх хугацаа энэ үед эхлэх бөгөөд үүнээс өрсөж АСЕАН-ы хамтын нийгэмлэгийг бий болгож байж сая АСЕАН-ы орнууд зах зээлд Хятадтай өрсөлдөхүйц эдийн засгийн хувьд хараат бус, харилцан хамаарал бүхий хамтын ажиллагааг амжилттай хөгжүүлэх боломжтой ажээ.

Эдүгээ АСЕАН-ы орнууд АФТА-г бүрэн хэрэгжүүлэхэд тохиолдож буй гол бэрхшээл нь гишүүн орнуудын хөгжлийн түвшин нэн ялгаатай байгаад оршино. Тухайлбал, АСЕАН-ы хуучин гишүүн Сингапурын 1 хүнд ногдох ДНБ-ий хэмжээ 36.000 ам.доллар байхад сүүлд элссэн Камбожийнх 1.000 хүрэхгүй ам.доллар байх жишээтэй.

Чухам үүний тул АСЕАН-д сүүлд элссэн 4 орны хөгжлийн түвшинг бусад гишүүн орнуудтай нь ойролцоо болгох явдал хойшлуулшгүй ажил болоод байна. АСЕАН-ы орнууд энэ асуудлыг шийдэхдээ дээрх 4 оронд 1) дэд бүтэц, 2) хүний нөөц, 3) орчин үеийн мэдээлэл холбоог хөгжүүлэх чиглэлийн хэд хэдэн төслийг яаралтай (6 жилийн хугацаанд) хэрэгжүүлэх хөтөлбөр боловсруулжээ. Үүнд:

Дэд бүтцийн хувьд төмөр зам, авто зам, усан зам, агаарын тээврийн сүлжээг бий болгож АСЕАН-ы бусад орнуудтай эрчим хүчний шугамаар холбогдох юм. Хүний нөөцийг хөгжүүлэхдээ сургалтын хөтөлбөрийг бусад гишүүн орнуудтай нийцүүлж, нийтийн боловсрол, мэргэжлийн сургалтын орчин үеийн ололтыг яаралтай нэвтрүүлэх ажээ. Мэдээлэл холбооны чиглэлээр орчин үеийн технологийг эзэмшихэд нь АСЕАН-ы бусад орнууд хамтын хүчээр туслаж байна.

Яагаад АСЕАН-ы хамтын ажиллагааг хамтын нийгэмлэгийн түвшинд яаралтай хүргэхийг мэрийх болов гэдгийг арай өргөн утгаар тайлбарлавал энэ нь АСЕАН-ы орнуудын хөгжлийн бодит шаардлагаас урган гарсан зүйл. Өөрөөр хэлбэл АСЕАН+1, АСЕАН+3-ийн хөгжлийн хандлага, өнөөгийн дэлхий ертөнцийн хөгжил, тухайлбал даяаршлын үйл явцын улмаас тулгарч буй өрсөлдөөний олон сорилтыг даван туулахад гагцхүү Зүүн Өмнөд Азийн 10 орны томоохон нэгдсэн зах зээл буюу бүсийн хамтын нийгэмлэгийг бий болгох шаардлага тулгарсантай холбоотой.

2. АСЕАН+3-ын хөгжлийн явц

Зүүн Азийн бүс нутагт АСЕАН+3 хэмээх хамтын ажиллагааны үйл явц бүрэлдэж байгаа билээ. Үүнд АСЕАН-ы гишүүн 10 орон дээр Зүүн Азийн нөлөө бүхий 3 орон (Хятад, Япон, БНСУ) нийлж байгаа юм. Эдгээр улс орнуудыг газар нутгийн байршлаар нь “Зүүн Азийн тал дугуй” гэж нэрлэх нь бий. Энэ тал дугуйд орших орнууд ХХ зууны

II хагасаас эрчимтэй хөгжих замд орохдоо түүхэн хөгжлийн гадаад дотоод нөхцөл байдлаас шалтгаалан нэг нь нөгөөдөө хөгжлийн аятай нөхцөл бүрдүүлж ирсэн түүхтэй. Зүүн Азийн орнуудын хоорондын худалдаа, хөрөнгө оруулалт хэдэн арван жил үргэлжилсэн бөгөөд 80, 90-ээд онд улам идэвхжсэн юм. Хөрөнгө оруулалтын салбарт Япон улс тэргүүлж 60, 70-аад оноос үйлдвэрлэлийн сүлжээг эхлүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн билээ.

Тухайлбал 70-аад онд Японы хөрөнгө оруулалт хөрш зэргэлдээх орнууд руугаа урсч, Япон улсын үйлдвэрлэлийн нэг хэсэг хил залгаа орнуудад шилжсэн бол 80-аад онд шинээр аж үйлдвэржсэн орнууд бий болж 80-аад оны эцсээр Япон болон шинээр аж үйлдвэржсэн “Барууд” АСЕАН-ы орнуудруу үйлдвэрлэлээ шилжүүлж дараа нь Хятад руу тэр урсгал орж эхлэв. 1995 он гэхэд Зүүн Азийн хөгжиж буй бүх орнууд дахь хөрөнгө оруулалтын 50% нь тус бүсийн доторх Япон болон “Бар” орнуудаас оржээ. Үүнийг дагалдаж Зүүн Азийн орнуудын худалдааны эргэлт үлэмж өсөв.

Ийнхүү Зүүн Азийн орнуудын үйлдвэрлэл худалдааны сүлжээ эдийн засгийн өсөлтийн эрэлт хэрэгцээний дагуу аяндаа бий болсон бөгөөд энэ нь Зүүн Азийн шинэ регионализмын аятай хөрсийг бий болгосон байна. Нөгөө талаар 90-ээд оны дунд үеэс эхэлсэн Зүүн Азийн санхүүгийн хямрал эдгээр орнуудад олон зүйлийг ойлгуулав.

1. Юуны өмнө тэдгээр орны эдийн засаг-санхүүгийн харилцан хамаарлыг гүнзгий мэдрүүлэв. АСЕАН-ы зарим оронд санхүүгийн хямрал эхэлмэгц тэр нь Япон, Солонгосын эдийн засаг санхүүд шууд нөлөөлсөн бөгөөд Японы санхүүгийн дэмжлэггүйгээр хямралаас гарах аргагүй нь АСЕАН-ы орнуудад тодорхой байв. Тэрчлэн Хятад улс мөнгөнийхөө ханшийг тогтвортой барьж, БНСУ-ын эдийн засаг түргэн сэргэсэн зэрэг хүчин зүйлс АСЕАН-ы эдийн засаг сэргэхэд шууд нөлөөлөв. АСЕАН-ы эдийн засаг сэргэж байгаа нь эргээд Япон, Солонгос, Хятадын эдийн засагт эерэгээр нөлөөлсөн байна.

2. Аяндаа үүссэн эдийн засаг-үйлдвэрлэлийн сүлжээ нь хөгжлийнхөө явцад зах зээлийн өрсөлдөөний улмаас ургаж гарсан олон асуудалтай тулгарч байгаа нь харагдав. Эдгээр асуудлыг аль нэг орны эрх ашгийн үүднээс биш, бүх улсуудын нийтлэг эрх ашгийн үүднээс шийдэхэд хамтын хүчин чармайлтыг шаардав.

Ийнхүү эдийн засгийн хөгжлийн динамик хуулиар аяндаа бий болсон (ямар нэг бодлогоор зохицуулж бий болгоогүй) эдийн засаг зах зээлийн нягт хамаарал нь Зүүн Азийн бүлэг улсуудыг дуртай ч, дургүй ч эдийн засаг-санхүүгийн үйл ажиллагаагаа уялдуулан зохицуулах олон талт механизм бий болгох зам руу түлхжээ. Энэ нь Зүүн Азийн орнуудад өөрсдийгөө алив эрсдлээс хамгаалах, улмаар даяаршил- регионализмын нөхцөлд өрсөлдөх чадвараа дээшлүүлж Ази, Номхон далайн бүс нутагт

байр сууриа бэхжүүлэх таатай нөхцлийг бүрдүүлж байгаа юм.

90-ээд оны санхүүгийн хямралаас авсан нэгэн сургамж бол эдийн засаг, санхүүгийн хүнд нөхцөлд АНУ-д түшиглэсэн барууны санхүүгийн тусламжинд хэт найдаж болохгүй гэдэг нь ч тодорхой харагдав. Өөрөөр хэлбэл АПЕК, АСЕМ-ын зүгээс туслах боломж харагдаагүй бөгөөд тэр үед Олон Улсын Валютын Сан өөрсдийн болзлыг тулгах нь ихэссэн зэрэг гаж үзэгдэл мэдрэгдэв. Түүнчлэн АПЕК-ын үйл ажиллагаа албан ёсны болж АНУ-ын зүгээс түүнийг либералчлахыг яаруулах болсон явдал Зүүн Азийнхныг түгшээж эхэлсэн байна. Энэ бүхэн нь Зүүн Азийн шинэ регианолизм үүсч үйл ажиллагаа нь идэвхжихэд нөлөөлжээ. Нөгөө талаар олон улсын бусад байгууллага, олон талт хамтын ажиллагааны механизмд оролцох Зүүн Азийн орнуудын нэр хүнд, нөлөөг ихэсгэх нь өнөө үед мөн л чухал болоод байна. Жишээ нь: Олон Улсын Валютын Сан, Дэлхийн Худалдааны Байгууллага, АПЕК зэрэг эдийн засгийн олон талт байгууллагуудад оролцож буй АНУ-ын арга ажиллагааны өмнө Азийн орнууд үнэндээ хүчин мөхөс байгаа билээ. Үүнд хүчний тэнцвэр бий болгох, өөрөөр хэлбэл дэлхийн эдийн засгийн талбарт эн тэнцүү тоглогч болох хүсэл эрмэлзлэл шинэ регионализмд хамрагдагч эдгээр орнуудад байгаа нь тодорхой.

Зүүн Азийн орнуудын эдийн засаг, худалдааны хэмжээ АНУ, Европын холбооноос дутах юмгүй атлаа нэгдсэн зохион байгуулалт сул байгаа нь эдийн засгийн олон талт байгууллагуудад тэдний дуу хоолой үл сонсогдом байгааг зарим судлаачид цохон тэмдэглэж, хэрвээ Зүүн Азийн регионализм хүчтэй болох аваас АНУ, ЕХ, Зүүн Азийн эдийн засгийн томоохон гурвалжин бий болно хэмээн үзэж байна.

Зүүн Азийн орнууд олон талт хамтын механизм бий болгохын тулд багагүй зам туулав. Тухайлбал Зүүн Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэг (ЕАЕС) байгуулах тухай 1990 оны Малайзын санал амжилт олсонгүй. Дараа нь 1995 онд АСЕАН-ы орнуудын удирдагчид Банкокт чуулж нэгэн санаачлага гаргав. Энэ нь АСЕАН-ы 10 орон болон Хятад, БНСУ, Японы удирдлагуудын уулзалт хийх санал байв. Чухамхүү энэ үеэс АСЕАН+3-ын хамтын ажиллагаа бий болох анхны шав тавигджээ.

1997 оны эцсээр Малайзын Куала-Лампур хотод АСЕАН-ы орнуудын удирдлага Япон, Хятад, БНСУ-ын удирдлагатай анхны хамтарсан уулзалт зохион байгуулав.

Энэхүү уулзалтаар АСЕАН+3-ын хамтын ажиллагааны хөтөлбөр баталжээ. Энэ хөтөлбөрийн дагуу хоёр дахь уулзалтыг 1998 онд АСЕАН-ы орнуудын Дээд уулзалтын үеэр Ханойд хийсэн бөгөөд дараагийн уулзалт Филиппины Манил хотноо 1999 оны эцсээр болж Зүүн Азийн хамтын ажиллагааны тухай хамтарсан мэдэгдлийг батлав.

Хамтарсан мэдэгдэлд АСЕАН+3-ын үйл ажиллагааны үндсэн

зарчмыг баталж хамтын ажиллагааны гол салбаруудыг тодорхойлжээ. Үүнд юуны өмнө АСЕАН+3-ын хамтын ажиллагаа нь энхтайвнаар зэрэгцэн орших 5 зарчим, 1976 оны Балийн гэрээний зарчим, олон улсын хуулийг мөрдлөг болгох ажээ. Зүүн Азийн хамтын ажиллагаа нь худалдаа, хөрөнгө оруулалт, мөнгө санхүү, шинжлэх ухаан-технологи, үйлдвэр-хөдөө аж ахуйн салбарыг хамарна хэмээн заав.

Түүнийг хэрэгжүүлэх механизм нь жил тутмын дээд уулзалт, яамдын сайд нарын болон салбарын мэргэжилтнүүдийн уулзалт ажээ. Өнгөрсөн хугацаанд АСЕАН+3-ын хамтын ажиллагааны механизм үндсэндээ төлөвшиж 2001, 2008 онд дээд удирдлагын болон салбарын сайд нар, мэргэжилтний уулзалтууд удаа дараа болж бодлого чиглэлээ боловсронгуй болгосоор байна.

АСЕАН+3-ын хамтын ажиллагаа эдүгээ эдийн засаг, санхүүгийн салбарт голлон төвлөрч байна. АСЕАН+3-ын орнууд эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэхдээ юуны өмнө худалдаа, хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, чингэхдээ аль болох шинэ технологи бие биендээ шилжүүлэх ялангуяа мэдээллийн техник технологийн салбарт хамтран ажиллахыг онцлон үзэх, өөр хоорондоо интернет худалдааг хөгжүүлэх, худалдааг нээлттэй байлгаж, түүнд хөгжингүй орнууд болон эдийн засгийн бүсүүдийг хамруулах, Зүүн Ази дахь хүний хөгжлийн нөөцийг хөгжүүлэхэд хамтын хүчин чармайлтыг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлалын салбарт хамтын ажиллагааг хүчтэй болгох, олон улсын болон бүс нутгийн олон талт хамтын ажиллагаанд үйл ажиллагаагаа зохицуулж хамтран ажиллахаар тохиролцон ажиллаж байна.

АСЕАН+3-ын мөнгө санхүүгийн салбар дахь хамтын ажиллагаа харьцангуй түргэн хөгжиж байна. Өнгөрсөн хугацаанд Сангийн сайд нарын уулзалт, Азийн хөгжлийн банктэй хамтарсан уулзалт удаа дараа хийжээ. АСЕАН+3-ын сайд нарын уулзалт жилд нэг удаа болох боловч Санхүү эдийн засгийн сайд нар шаардлагатай гэсэн үедээ уулзалдах болов. Азийн эдгээр орнууд юуны өмнө банк санхүүгийн туршлагаа солилцож, бие биенээс суралцах ажлаа эрчимжүүлж байна. АСЕАН+3-ын банкны удирдлагууд 2 жил тутам уулзаж мөнгө санхүүгийн салбарын хамтын ажиллагааны шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг гүйцэтгэх болжээ.

АСЕАН+3-ын удирдлага сүүлийн үед Азийн валютын сан байгуулах, Японы иенийг олон улсын валют болгох чиглэлээр ажиллах санаачлагыг дэвшүүлж байна. Мөн санхүүгийн аливаа хямралыг таслан зогсоох зорилгоор мөнгө санхүүгийн дэмжлэг харилцан үзүүлж байх тогтолцоог бий болгох хөтөлбөрийг баталжээ. Үүний тулд юуны өмнө АСЕАН+3-ын хамтын сан (1 тэрбум орчим ам.доллар) байгуулав. Мөн гаднаас орж ирэх богино хугацаат хөрөнгө оруулалтын урсгалыг

хянаж байх, түүний сөрөг нөлөөг хязгаарлах, түүнтэй тэмцэх зохистой аргуудыг хамтран хайх болжээ. АСЕАН+3-ын хооронд валютын арилжааны тогтолцоог боловсронгуй болгож солилцоог өргөжүүлэх ажил нэн ахицтай байна.

АСЕАН+3-ын орнууд гадаад худалдааны хувьд харьцангуй бие даасан бодлоготой бөгөөд Дэлхийн Худалдааны Байгууллага, АПЕК-ын хүрээнд худалдааны олон талт харилцааг хөгжүүлэхийг эрмэлзэж байна. Үүний хамт Зүүн Азийн чөлөөт худалдааны бүс (ЕАФТА) бий болгох боломжийг Зүүн Азийн судалгааны байгууллага тусгайлан судалж хөтөлбөр боловсруулж байна. Худалдааны хамтын ажиллагаа нь эхний шатанд 2 талын чөлөөт худалдааны бүс байгуулж, гааль татварын давуу нөхцөл бүрдүүлж чөлөөт худалдааг дэмжих замаар хөгжиж байна.

Сүүлийн үед АСЕАН-ы холбоо болон түүний доторх зарим гишүүн орнууд Зүүн Хойд Азийн зарим орнуудтай 2 талын чөлөөт худалдааны гэрээнд гарын үсэг зурж эхлэв. Үүнд Сингапур нэн идэвхтэй байгаа бөгөөд Тайланд удаалж байна. Хятад улс АСЕАН-ы орнуудтай олон талын болон 2 талын чөлөөт худалдааны гэрээ хийх нь худалдааг өргөжүүлэх эдийн засгаа глобальчлах бодлогын нэг хэсэг хэмээн үзэж байна. 2000 онд АСЕАН ба Хятадын тал чөлөөт худалдааны бүс байгуулах гэрээнд гарын үсэг зурав. Энэ гэрээг хэрэгжүүлэх эхний алхмаа 2004 оноос хийж эхлэв.

Үүний зэрэгцээ Хятад улс Тайландтай чөлөөт худалдааны гэрээнд гарын үсэг зурав. Эхний шатанд хүнсний ногоо, жимс жимсгэний салбарт чөлөөт худалдааг эхлүүлэхээр тохирчээ. Мөн Сингапур улс Хятадтай чөлөөт худалдааны гэрээнд гарын үсэг зуржээ. Япон улс энэ үйл явцаас хоцрохгүйг хичээж АСЕАН-тай чөлөөт худалдааны гэрээ байгуулахаар шийдвэрлэв. Япон, Сингапурын чөлөөт худалдааны гэрээ байгуулагдав. Мөн Өмнөд Солонгосын тал Тайланд, Филиппинтэй чөлөөт худалдааны гэрээ байгуулж байна.

Ийнхүү АСЕАН-ы зарим орнууд Зүүн Хойд Азийн 3 оронтой тус тусад нь 2 талын чөлөөт худалдааны гэрээ байгуулж байгаа нь АСЕАН+3-ын үйл явц урагшилж байгаагийн нэг илрэл боловч нэг талаас АСЕАН-ы холбоо, нөгөө талаас Хятад + Япон + Солонгос 3-ын нэгдсэн зах зээл бүрэлдэхэд бас ч амаргүй бололтой. АСЕАН-ы орнууд Зүүн Хойд Азийн орнуудтай 2 талын гэрээ байгуулж байгаа байдлыг ажиглавал эдийн засгийн чадавхитай томоохон орнуудын хооронд энэ үйл явц өрнөж байгаа нь тодорхой байна. Хөгжлөөр буурай Лаос, Камбож, Бирм, Вьетнам мэт нь энэ үйл явцаас хоцорч байгаа нь ажиглагдана. Энэ нь аливаа чөлөөт худалдааны гэрээ нь эдийн засгийн чадавхитай орнуудад өөрөөр хэлбэл зах зээлд өрсөлдөх бараа бүтээгдэхүүнтэй улс орнуудад ашигтай бөгөөд өрсөлдөх чадвараар сул орнуудад төдийлөн ашигтай

биш байдагтай холбоотой юм.

Нөгөө талаар АСЕАН-ыг үүсгэн санаачлагч 6 орны эдийн засаг нь интеграцийг шаардаж байхад хожим элссэн 4 орны эдийн засгийн хөгжлийн төвшин доогуур учир 2 талын чөлөөт худалдааны гэрээнд оролцоход бэлэн биш байгааг харуулж байна.

АСЕАН+3-ын интеграци гэдэг нь АСЕАН-ы орнуудын томъёолол бөгөөд агуулга нь АСЕАН төвтэй Зүүн Өмнөд Азийн эдийн засгийн интеграцийг хэрэгжүүлэх явдал юм. АСЕАН+3 амжилттай хэрэгжих эсэх нь АСЕАН-ы орнуудын өөр хоорондын эдийн засгийн интеграци хэр амжилттай хэрэгжиж бүс нутгийн хэмжээгээр эдийн засгийн өрсөлдөх чадамжаа хэр дээшлүүлэхээс шууд шалтгаална. Тийм учраас АСЕАН-ы орнууд үүний төлөө цаг наргүй шамдаж байна.

Зүүн Азийн орнуудын хамтын нийгэмлэг хэрэгжихэд АСЕАН өөрөө түүний эн тэнцүү бүрэлдэхүүн хэсэг болох зорилготой. Хятад улс мөн л Зүүн Азийн эдийн засгийн интеграцид идэвхтэй оролцох бэлтгэлийг шургуу хийж байна. Алс нь Зүүн Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгт манлайлагч нөлөө бүхий орон болох мөрөөдөл хамт байгаа. Энэ зорилгоор Хятад улстай Зүүн Азид өрсөлдөгч нөгөө нэг орон нь Япон билээ. Энэ 2 томоохон өрсөлдөгч эдүгээ АСЕАН-ы орнуудтай чөлөөт худалдааны бүс байгуулахаар тус тусдаа тохиролцож, үйл ажиллагаа нь нэгэнт эхэлсэн билээ.⁶

АСЕАН+Хятадын хооронд чөлөөт худалдааны гэрээ байгуулсан нь Хятад улсын хувьд шинэ томоохон зах зээл нээх, Зүүн Өмнөд Азид байр сууриа бэхжүүлэх алхам хэмээн тооцож байна. АСЕАН-ы хувьд Хятадтай чөлөөт худалдааны бүс байгуулах нь АНУ, Япон зэрэг том эдийн засгийн эргүүлэгт гүн татагдах эрсдлийг хязгаарлаж том эдийн засгуудын хүчний тэнцвэрийг Зүүн Өмнөд Азид бий болгох ач холбогдолтой хэмээн үзэж буй.

Япон улс үүнээс хоцрохгүйг хичээн тэр дороо Зүүн Өмнөд Азийн хэд хэдэн оронтой 2 талын чөлөөт худалдааны бүсийг байгуулж улмаар АСЕАН+Японы чөлөөт худалдааны бүс байгуулахаар шийдэв. Үүний хамт Япон+Солонгосын 2 талын чөлөөт худалдааны бүсийн тухай яриа хэлцэл явагдаж байна. Энэ нь Хятадын том эдийн засагтай яаж ийгээд эн тэнцүү болох гэсэн, улмаар Зүүн Азийн хамтын нийгэмлэгт Японы ролийг нэмэгдүүлэх гэсэн зорилготой юм.

АСЕАН-ы хувьд Япон, Солонгос нь эдийн засгийн интеграцид нэгдэж Хятадаас хол дутахааргүй чадамжтай болохыг дэмжиж байна. Учир нь энэ 2 орны эдийн засгийн чадамж нөлөө их болбоос Зүүн Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэг аль нэг том орны нөлөөнд орохоос сэргийлэх ач холбогдолтой ажээ.

Зүүн Хойд Азийн 3 орны (Хятад, Солонгос, Япон) хооронд

чөлөөт худалдааны бүс (FTA) байгуулах саналыг Хятад улс тавьж буй боловч Япон улс болгоомжилж байна. Япон нь Солонгостой чөлөөт худалдааны бүс FTA байгуулж байж оролцох бодлоготой ажээ. Гэвч Өмнөд Солонгос үүнд бэлэн биш байна. Солонгос нь Япон Хятадтай тус тусад нь FTA байгуулахаас болгоомжилж Зүүн Хойд Азийн 3 орны хамтарсан FTA-г алс нь байгуулбал Солонгост илүү хожоотой хэмээн үздэг ажээ. Ер Зүүн Хойд Азийн худалдааны гол төв болох геополитикийн нөхцөлтэй гэж үздэг бөгөөд түүнд нь дөхөм болох ажээ.

Энэ бүхэн эцсийн эцэст Зүүн Хойд Азийн хамтын нийгэмлэгийн үйл явц эргэлт буцалтгүй болсныг мэдэрсэн улс орнуудын бодлого үйл ажиллагаа бөгөөд одоохондоо Зүүн Хойд Азийн 3 орон хамтарсан FTA байгуулахад зарим нэг бэрхшээл байгааг харуулж байна.

Харин АСЕАН+Хятад, АСЕАН+Япон, АСЕАН+Солонгос гэсэн бүтэц бүхий FTA-г илүү сонирхож байгаа нь тодорхой байна. Энэ нь АСЕАН төвтэй Зүүн Азийн интеграци буюу чөлөөт худалдааны бүсийг бий болгох гэсэн АСЕАН-ы бодлогод ашигтай байна.

Хэдий тийм боловч яваандаа Зүүн Хойд Азийн 3 орон нийлж АСЕАН-ы худалдааны чөлөөт бүс АFTA-д нэгдэж АСЕАН+3 хэмээх бүтэц бий болж улмаар Зүүн Азийн (АСЕАН+Хятад+Япон+Солонгос) худалдааны чөлөөт бүс (EAFTA) үүсэх нь тодорхой бөгөөд тэр үед АСЕАН-ы роль нөлөө буурах нь зүй тогтлын гэмээр үнэн билээ.

Дээр дурдсан баримтаас үзэхэд үйл явц давшингүй өрнөж байгаа нь тодорхой байна. АСЕАН+3 ба Зүүн Азийн хамтын нийгэмлэг бий болоход чиглэсэн үйл явцыг Монгол улс сонирхохгүй байхын аргагүй. Эдгээр үйл явцад бид нэгдэх ямар боломж арга зам ба бэрхшээл сорилт байгааг тал бүрээс нягтлан судлах нь хойшлуулшгүй ажил хэмээн үзнэ.

3. Интеграцид нэгдэх Монгол улсын боломж ба сорилт

Орчин үеийн эдийн засгийн интеграци даяаршил зэрэгт хөл нийлүүлэх нь аль ч улс орны хувьд хоцорч болохгүй чухал зүйл. Хөгжлөөр буурай орнууд түүнд оролцохын тулд юуны өмнө өөрийн давуу талд түшиглэсэн аж үйлдвэрийн салбарыг аль болох түргэн хөгжүүлэх, түүгээрээ олон улсын зах зээлд өрсөлдөх чадвараа бий болгох ёстой. Эдүгээ хөгжиж буй бүх улс орон үүний төлөө цаг наргүй уралдаж байна. Бидний давуу тал гээд байгаа юм маань:

1. Байгалийн баялаг. Энэ баялгийг нээж ашиглах Монгол улсын стратеги бодлого гэвэл гадаадын хөрөнгө оруулалтыг татах, улмаар эцсийн боловсруулалт хийж гадаад зах зээлд гаргах явдал билээ. Гэтэл энд улс дамжсан том корпораци том хөрөнгө оруулалт шаардагдаж буй. (Жижиг орон хөрөнгө оруулахгүй, учир нь тэдний хөрөнгийн чадвар дутна) Чухамдаа зэс, алт, нүүрс, нефть зэрэг ашигт малтмалын

томоохон ордуудад том гүрний сонирхол байгаа боловч Монгол улсын бодлого ба эрх зүйн орчин нь тогтвортой биш, зарим тохиолдолд улс төрийн хийрхэл хүчтэй нөлөөлж байдаг зэрэг таагүй байдлаас тэдний сонирхол өөр тив, бүс рүү хандах хандлага бий. Нөгөө талаар аливаа байгалийн баялаг хязгаартай бөгөөд мөнхийн зүйл биш. Иймд улс орны хөгжилд түр зуур нөлөөлөх хүчин зүйл болдог билээ.

2. Мал аж ахуйн түүхий эд ноос, ноолуур, арьс шир, мах, сүү г.м. 40-өөд сая малтай нэг хүнд 15 толгой мал оногддог Монгол улсын хувьд малын гаралтай түүхий эдийг орчин үеийн технологид түшиглэн чанартай бүтээгдэхүүн хийж чадвал цөөн хүн амтай Монгол улсын хувьд багагүй баялаг билээ. Иймд өртөг хямд бөгөөд олон улсын зах зээлд өрсөлдөхүйц чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд мөн л гадаадын хөрөнгө оруулалт, түүний шилдэг техник технологи, мөн орчин үеийн үндэсний технологи зайлшгүй шаардлагатай. Энэ салбарын бүтээгдэхүүн нь олон улсын зах зээлд өрсөлдөхүйц байх боломжтой. Одоо Монгол улсын ноолууран бүтээгдэхүүн, зарим төрлийн хивсний чанар чансаа өрсөлдөх чадварын хувьд муугүй гэж хэлж болно. Хэрвээ арьс ширний боловсруулалтад шинэ технологи нэвтрүүлж түүний өөрийн өртгийг хямдруулж чадвал мөн зах зээлд өрсөлдөх боломж бүрдэнэ.

ХАА-н гаралтай хүнсний бүтээгдэхүүний эрүүл ахуй, сав баглаа боодолд анхаарч түүний үйлдвэрлэлд орчин үеийн шинжлэх ухаан технологийн ололтыг нэвтрүүлж чадвал мөн өрсөлдөх боломж дээшилнэ. Монгол улсын хувьд өнө мөнхийн үнэ цэнээ үл алдах бүтээгдэхүүн нь эдгээр билээ. Иймд энэ салбарт шинжлэх ухааны ололт, шинэ технологийг байнга нэвтрүүлж үйлдвэрлэлийн чанарыг дээшлүүлж өөрийн өртгийг хямдруулахыг хичээх нь төрийн бодлогын анхаарлын төвд байнга байх ёстой юм. Энэ нь үндэсний шинжлэх ухаан, ялангуяа суурь болон хавсарга шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүнд үлэмжхэн хөрөнгө хуваарилахтай холбоотой зүйл. Аливаа улс орны ХАА-н гаралтай бүтээгдэхүүн нь тухайн улсын стратегийн бүтээгдэхүүн байдаг учир бусад орны энэ төрлийн бараанд орон зайгаа тавьж өгөхөөргүй дээд зэргийн чанар чансаатай байлгах нь төрийн бодлогын нэг хэсэг билээ. Энэ төрлийн бараагаар дэлхийн зах зээлд өрсөлдөх боллоо хөгжүүлэхэд мөн л хөрөнгө, цаг хугацаа шаардагдах учир одооноос бодлоготой хэрэгжүүлэхээс өөр аргагүй.

3. Монголчуудын оюун ухаан, авхаалж самбааг хэнээс ч дутахгүй гэлцдэг. Энэ нь мэдээлэлд суурилсан сүлжээний чиглэлтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд нэгдэн орох боломж бий гэсэн үг. Энэ чиглэлийн салбарыг хөгжүүлэх санаа сэдэл мэр сэр гарсаар байдгийг дэмжиж ажил хэрэг болгох, үүний тул тулхтай хөтөлбөрийг Засгийн газрын хэмжээнд боловсруулж хэрэгжүүлэх ажлыг хойшлуулмааргүй байна. Энэ бол бид өөрсдийн оюуны чадварыг ашиглаж оюуны бүтээгдэхүүн

үйлдвэрлэж баялгийг бүтээх томоохон эх сурвалж билээ. Энэ чиглэлээр бүсийн болон олон улсын зах зээлд өрсөлдөх боломж бий. Монгол улс нь цөөн хэдхэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж түүнийхээ заримыг бусад орноор дамжуулан тээвэрлэж экспортлодог. Нутаг дэвсгэрийн хэмжээнд эрчим хүч дутагдалтай цөөн хэдэн орны нэг. Иймд улс орон даяар үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хүндрэлтэй. Гагцхүү хүний хөгжилдөө тулгуурлаж өндөр өртөг шингэсэн ийм төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд нэгдэх зам бол Монгол улсын хувьд хөгжлийн хамгийн чухал гарц гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой.

4. Манайд мөн байгаль, соёлын аялал жуулчлалын салбарыг улс орны хөгжлийн нэг хөшүүрэг болгох боломж бий. Үүний тулд дэд бүтцийг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үзвэр, үйлчилгээг орчин үеийн болгоход чиглэгдсэн томоохон хөрөнгө оруулалт шаардлагатай.

Монгол улс өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, машин техник, тэр болгоныг үйлдвэрлэх боломжгүй учир өөрийн харьцангуй давуу талд түшиглэсэн дээрх цөөн хэдэн төрлийн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээгээр олон улсын чөлөөт зах зээлд нэгдэж эдийн засгийн интеграцид оролцох боломжтой.

Бид регионализмын сайн талыг нэн сайн мэдэх бөгөөд түүнд нэгдэхийн чухлыг гүнзгий ойлгодог хирнээ түүнд нэгдэхэд багагүй бэлтгэл хэрэгтэйг өнөө хэр ярихгүй байгаа нь харамсалтай.

АСЕАН-ы гишүүн орнуудын туршлагаас харахад аливаа регионализмд нэгдэн оролцоход буурай хөгжилтэй орнууд нилээдгүй бэрхшээл сорилттой тулгардаг нь тодорхой байна.

Бүс нутгийн интеграцид үр ашигтай оролцоно гэдэг нь эрх тэгш харилцан хамааралтай байна гэсэн үг. Үүний тулд олон улсын буюу тухайн бүс нутгийн зах зээлд өрсөлдөх чадвартай байх ёстой.

Эс тэгвэл бусдын бараанд зах зээлээ эзлүүлж өөрийн үйлдвэрүүд ажилгүй болно. Үүнээс болж эдийн засаг уналтанд орж бусдын хавсарга эдийн засаг болж хувирна. Эдийн засгийн аюулгүй байдал бүрмөсөн унана.

Эдүгээ Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдал ноцтой алдагдаад байгааг зарим судалгаа нотолсоор байна. Энд би доктор Д.Тунгалагийн Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдалд хийсэн зарим үзүүлэлтийг иш татъя.⁷

Монгол улс эдийн засгийн аюулгүй байдлын 15 үзүүлэлтээс 11 үзүүлэлт аюулгүй байдлын босгын шалгуурыг хангахгүй гарчээ. Энэ үзүүлэлт сүүлийн жилүүдэд улам ч хангалтгүй болсоор байгаа нь түгшүүр төрүүлж байна. Зарим жишээ дурьдвал:

1. Хүнсний хэрэглээнд импортоор авч буй хувь 30%-ийн босготой байхад 48.7%-д хүрсэн байна.

2. Гурилын хэрэглээнд импортоор авч буй хувь 30%-иас хэтэрч

болохгүй атал 60 гаруй хувьд хүрчээ.

3. ДНБ-д импортын эзлэх жин 30%-иас давах ёсгүй. Гэтэл энэ үзүүлэлт 2004 оноос 68.3%-д хүрсэн.

4. Гадаад өр зээл ДНБ-ий 60%-иас хэтэрвэл улс төр эдийн засгийн хувьд хараат байдалд оролцох аюултай атал 88.9%-д хүрчээ.

5. Нийт экспортод түүхий эдийн эзлэх хувийн жин 60%-иас хэтэрвэл гадаад орны түүхий эдийн нийлүүлэгч хавсарга жинтэй эдийн засгийн бүтцийг бий болгодог. Гэтэл үүнээс давчээ.

6. Манай улсад орж ирж буй нийт хөрөнгийн 60% нь зөвхөн уул уурхайн олборлох салбарт орж ирсэн явдал нь хөрөнгө оруулалтын бүтэц хэт өрөөсгөл байгааг харуулжээ. Өөрөөр хэлбэл Монгол улсын хэтийн хөгжлийн стратегид ач холбдол бүхий аж ахуй үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтыг чиглүүлэх бодлого дутагдаж байна гэсэн үг. Д.Тунгалагийн энэхүү судалгаанаас үзэхэд манай улсын боловсруулах үйлдвэрлэл уналтанд орж экспортын уул уурхайн олборлох ба хагас боловсруулсан түүхий эд материалыг шүтсэн эдийн засгийн бүтэц бүрэлдэж байгаагаас эдийн засгийн тогтвортой хөгжлийн баталгаа алдагдаж, эдийн засгийн аюулгүй байдал доголдож байна.

Монгол улс хүнсний ихэнх гол нэрийн бүтээгдэхүүн (мах, сүүнээс бусад) бараг бүх төрлийн өргөн хэрэглээний хүнсийг гадаад зах зээлээс авч бүрэн хараат эх үүсвэрээр хангаж байгаа ажээ.

Энэхүү хараат байдлыг бууруулахын тулд хүнсний бүтээгдэхүүнийг аль болох дотооддоо үйлдвэрлэхийг хичээх, зарим шаардлагатай бүтээгдэхүүний хараат байдлыг бууруулахын тулд нэг орноос авах хэмжээг хамгийн бага байхуйцаар тогтоох шаардлагатай ажээ.

Манай эдийн засагчдын үзэж байгаагаар эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь гадаад орнуудын эдийн засагтай харилцан хамааралтай орших чадвартай, хүн амынхаа сайн сайхан байдлыг тогтвортой хангадаг эдийн засгийн тогтолцоог бүрдүүлсэн байдлыг хэлнэ гэжээ.

Монгол улсын 1994 онд баталсан “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 5-р бүлэгт эдийн засгийн аюулгүй байдлыг мөн ийм үндсэн санаагаар томъёолжээ.

Монголын эдийн засаг нь жижиг орны эмзэг эдийн засаг билээ. Манай улсын импортын эзлэх хувь хэмжээ өндөр, том хэмжээний эдийн засагт хараат болох магадлал ихтэй олон улсын үнэ ханшид нөлөөлөх боломжгүй, олон улсын зах зээлээс алслагдмал байршилтай учир тээврийн зардал өндөр г.м сул талтай.

Манай улс эдийн засгийн байдлаараа дэлхийн хамгийн эмзэг 20 орны нэгэнд багтдаг ажээ.⁸

Нөгөө талаар Монгол улс өөрөө маш жижиг зах зээлтэй, дэд бүтэц сайн хөгжөөгүй хувийн секторын томоохон аж ахуй хөгжөөгүй гэх мэт

шалтгаанаас хөрөнгө оруулалт сул орон билээ. Энэ нь бүс нутгийн эдийн засгийн интеграцид оролцох Монголын оролцоог хязгаарладаг. Бид өөрсдөө бүс нутгийн интеграцид оролцох сонирхолтой боловч АСЕАН, АСЕАН+3 мэтийн эдийн засгийн хамтын ажиллагааны бүсүүд биднийг төдийлөн их сонирхдоггүй. Учир нь тэр бүс нутгийн улс орнуудын давын өмнөх зорилго нь худалдааны чөлөөт бүсийг бүрэн утгаар хэрэгжүүлж улмаар хөрөнгө оруулалтыг татаж эдийн засгийнхаа чадамжийг дээшлүүлэн хамтын нийгэмлэгийн хэмжээнд яаралтай хүрч томоохон эдийн засгуудтай эн тэнцэхүйц хэмжээнд очиж тэдэнтэй харилцан хамааралтай, үр ашигтай хамтын ажиллагааг бий болгох явдал билээ. Ийм цаг үед Монгол мэт ач холбогдол багатай, буурай эдийн засгийг тус холбоонд нэгтгэх сонирхол бага юм.

Ийм нөхцөлд бид яах вэ? Ямар арга замаар энэ бүс нутгийн хамтын ажиллагаанд оролцох вэ? гэвэл эхний шатанд 1) АСЕАН+3-ын орнуудтай худалдаа, соёл боловсролын салбарт аль болохоор 2 талын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэл барих хэрэгтэй мэт. Энэ бол тэдэнтэй чөлөөт зах зээлд нэгдэх бэлтгэл шатанд нэн чухал. Тухайлбал 2 талын худалдаанд гааль татварын хөнгөлөлт үзүүлэх, боловсрол, соёлын солилцоог аль болох хөгжүүлэх, түүний үндсэн дээр бие биений нөөц бололцоог илүү судалж мэдэх гэх мэт. 2) Үүнээс гадна Монголын гадаад харилцааны тэргүүлэх чиглэлийн дагуу Монголд хөрөнгө оруулах боломжтой хөгжингүй орнууд буюу томоохон эдийн засгийн хөрөнгийг татахын тулд бүхнийг хийх хэрэгтэй. Үүний тул техникийн болон эдийн засгийн дэд бүтцийг хөгжүүлж эрх зүйн орчинг дээд зэргээр хөнгөвчлөх, зарим газар нутгаа олон улсын хөрөнгө оруулалттай чөлөөт бүс болгон тавьж өгөх зэрэг арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай.

Олон улсын хөрөнгө оруулалттай аж үйлдвэрийн парк байгуулах асуудлыг Монгол улс эрх зүйн хувьд шийдсэн боловч бодит амьдралд хэрэгжихгүй байна. Энэ нь манай орны хувьд аж үйлдвэрийн парк буюу үйлдвэрийн чөлөөт бүсийг байгуулахад юуны өмнө дэд бүтэц болон үйлчилгээний иж бүрэн барилга байгууламжийг Засгийн газраас хөрөнгө оруулж бий болгож өгөөд тэр орчноо бага түрээстэйгээр гадны хөрөнгө оруулагчдад өгч, үйлдвэрлэлээ явуулахад нь иж бүрэн үйлчилгээгээр хангах явдал билээ.

Чухамдаа үүнийг Засгийн газар оролцон зохион байгуулах хэрэгтэй. Хөрөнгө мөнгөний хүрэлцээ бага тохиолдолд аль нэг гадны хөрөнгө оруулагчтай хамтардаг туршлага ч бий. Тэр тохиолдолд талбайн хэмжээ буюу газар, бусад зүйлээр хөрөнгө оруулах боломжтой.

Монголын жижиг зах зээл дээр үйлдвэрээ бий болгох улс ховор байж болно. Ийм тохиолдолд хөдөлмөрийн хямд зах зээл, ажиллах хүчний

өндөр ур чадвар гэсэн давуу талыг ашиглаж болно. Гэхдээ манайд цалин нэмэгдэж байгаа болон ажилчдын мэргэжлийн сургууль ховордсон зэрэг сөрөг тал бас бий. Одоо энэ талаар анхаарч байгаа нь сайн хэрэг.

Бидний хил залгаа улс орнууд чөлөөт зах зээлд шилжвэл бид тэднээс хоцрох аргагүй болно. Иймд цаг алдалгүй бэлтгэлийг хангах өөрөөр хэлбэл орчин үеийн техник технологид тулгуурласан хамтарсан үйлдвэрлэлийг хөгжүүлэхээс өөр арга зам үгүй билээ.

Гадны хөрөнгө оруулалттай стратегийн чиглэлтэй үйлдвэрүүдийг яаралтай хөгжүүлсэн цагт бид улс орноо орчин үеийн эрсдлээс авч гарахаас гадна “АСЕАН+3”-ын чөлөөт зах зээлд амжилттай оролцох боломжтой болно.

Монгол Улс АСЕАН-ы орнуудын Балийн гэрээнд нэгдсэн явдал үүнд дөхөм үзүүлж буй. Энэхүү гэрээнд элссэн нь Монгол улс АСЕАН-ы орнуудын хамтын ажиллагааны үндсэн зарчмуудыг (тухайлбал, харилцан бие биений дотоод хэрэгт үл оролцох, аливаа асуудлыг консусын зарчмаар шийдвэрлэх г.м) хүлээн зөвшөөрч байгаа гэсэн үг бөгөөд эдгээр оронтой 2 талын аливаа харилцааг хөгжүүлэх анхны аятай нөхцлийг бүрдүүлж, үүнд эдийн засгийн шинжтэй аливаа төсөл, хэлбэртэй санаачлан оролцох боломжтой юм.

Монголчууд АСЕАН-ы АРФ болон Балийн гэрээнд нэгдсэн явдал олон талт хамтын ажиллагаанд оролцох туршлагыг өөртөө хуримтлуулахаас гадна хамтын ажиллагааны үйл явцуудыг биечлэн судалж үр ашигтай хамтрах аргад суралцах боломж өгч байгаа юм.

Ашигласан материал

1. Vai tro cua VN trong ASEAN, (АСЕАН дахь Вьетнамын роль) Hanoi 2007, 48-р тал
2. Kinh te cac nuoc DNA: Thuc trang va trien vong. (Зүүн Өмнөд Азийн орнуудын эдийн засаг: өнөө ба ирээдүй) Hanoi 2002, 118-119-р тал
3. Hoi nhap kinh te khu vuc cua mot so nuoc ASEAN. (АСЕАН-ы зарим орны бүс нутгийн эдийн засгийн интеграци) Hanoi 2002, 83-р тал
4. Vai tro VN... 37-р тал
5. Pham duc Thanh, Lien ket ASEAN trong tap nien dau the ky XXI, (АСЕАН-ы интеграци XX зуунд) Hanoi, 2006. 157-158-р тал
6. Huong toi Cong dong kinh te Dong A. (Зүүн Азийн эдийн засгийн хамтын нийгэмлэгийн зүгт) Hanoi 2004, 164-165-р тал
7. Д.Тунгалаг Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах арга зам “Стратеги судлал” сэтгүүл 2007, №2 116-128-р тал
8. Б.Сувд “Эдийн засгийн өнөөгийн байдал ба бодлого” Стратеги судлал, 2008 №7, 107-р тал